

БАЯН ЖАНЖИН ХИШИГ АУДИТ ХХК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баруунтуруун сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: УВА-2026/057/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Улаангом хот
2026 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,
Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь
Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn
Аудитын менежер: М.Бат-Амгалан
Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amqalanm@audit.gov.mn
Гэрээгээр аудитыг гүйцэтгэсэн Баян жанжин хишиг аудит
ХХК-ийн аудитор: А.Дугармаа
Утас: 99542180, Цахим хаяг: baynjanjinxishig@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	Error! Bookmark not defined.
Дүгнэлтийн үндэслэл	3
Асуудлыг онцолсон хэсэг.....	3
Аудитын гол асуудал	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	13
4.1 Ерөнхий зүйл	17
4.2 Материаллаг байдал.....	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
ТШЗ	Төсвийн шууд захирагч
НА	Нийцлийн аудит



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

2026-02-08 № УВА-2026/057/НА-СТН-ТНЗ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баруунтуруун сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баруунтуруун сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

АДБОУС 2706.7-д тодорхойлсон санхүүгийн тайланд толилуулсан, тодруулсан мэдээлэл байхгүй болно.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

8525050316

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>293,744,969.35</u>	<u>307,190,072.61</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	17,588.06	71,352,807.25
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	17,588.06	71,352,807.25
3121	Төгрөг	17,588.06	71,352,807.25
31211	Төрийн сангийн харилцах	17,588.06	71,352,807.25
33	АВЛАГА	178,259,047.80	52,098,271.96
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	178,259,047.80	36,990,737.35
335	Бусад авлага	00.00	15,107,534.61
3351	Байгууллагаас авах авлага	00.00	15,107,534.61
35	БАРАА МАТЕРИАЛ	115,468,333.49	183,738,993.40
351	Түүхий эд материал	33,564,581.56	143,098,957.00
35130	Эм боох материал	33,564,581.56	143,098,957.00
354	Хангамжийн материал	81,903,751.93	40,640,036.40
35410	Бичиг хэргийн материал	888,000.00	27,500.00
35420	Аж ахуйн материал	43,239,650.43	20,223,753.90
35440	Түлш, шатах тослох материал	15,165,000.00	1,100,000.00
35450	Барилгын засварын материал	14,934,435.00	17,500,935.00
35460	Хүнсний материал	7,676,666.50	1,787,847.50
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,555,866,678.62</u>	<u>1,414,338,905.28</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,555,866,678.62	1,414,338,905.28
392	Биет хөрөнгө	1,519,176,278.62	1,377,648,505.28
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,183,685,336.02	1,170,873,948.34
39202	Хуримтлагдсан элэгдэл	-182,019,623.18	-206,033,539.94
39203	Авто-тээврийн хэрэгсэл	287,219,366.47	287,219,366.47
39204	Хуримтлагдсан элэгдэл	-78,820,902.16	-122,208,783.22
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	677,986,144.72	677,986,144.72
39206	Хуримтлагдсан элэгдэл	-414,233,351.37	-499,578,176.78
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	68,043,495.40	74,543,495.40
39208	Хуримтлагдсан элэгдэл	-50,299,187.25	-56,315,228.99
39214	Бусад үндсэн хөрөнгө	90,603,769.00	118,865,313.39
39215	Хуримтлагдсан элэгдэл	-62,988,769.03	-67,704,034.11
393	Биет бус хөрөнгө	36,690,400.00	36,690,400.00
39301	Програм хангамж	440,000.00	440,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-440,000.00	-440,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	36,690,400.00	36,690,400.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III-I+II	<u>1,849,611,647.97</u>	<u>1,721,528,977.89</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>17,526,021.00</u>	<u>25,534,410.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	17,526,021.00	25,534,410.00
413	Өглөг	17,526,021.00	25,534,410.00

41310	Ажилчидтай холбогдсон өглөг	1,905,000.00	1,905,000.00
4136	Бусад өглөг	15,621,021.00	23,629,410.00
41361	Байгууллагад төлөх өглөг	15,621,021.00	23,629,410.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,832,085,626.97	1,695,994,567.89
51	Засгийн газрын хувь оролцоо	1,832,085,626.97	1,695,994,567.89
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	523,795,393.85	523,795,393.85
51101	Өмч: - төрийн	523,795,393.85	523,795,393.85
512	Хуримтлагдсан үр дүн	1,006,202,056.96	892,866,107.56
51210	Өмнөх үеийн үр дүн	1,006,202,056.96	1,028,957,166.64
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-136,091,059.08
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	302,088,176.16	279,333,066.48
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,849,611,647.97	1,721,528,977.89

2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,600,001,120.29	1,414,754,516.79
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	327,071,502.63	109,056,890.78
120	Нийтлэг татварын бус орлого	327,071,502.63	109,056,890.78
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	327,071,502.63	109,056,890.78
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	11,226,125.00	102,023,346.39
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,272,929,617.66	1,305,697,626.01
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	11,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	11,000,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	73,080,000.00	74,547,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	73,080,000.00	74,547,500.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,199,849,617.66	1,220,150,126.01
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,199,849,617.66	1,220,150,126.01
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,291,247,339.38	1,550,845,575.87
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,291,247,339.38	1,550,845,575.87
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,290,978,648.94	1,550,754,201.28
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	794,017,421.58	958,588,159.58
210101	Үндсэн цалин	481,590,922.60	545,891,908.13
210102	Нэмэгдэл	241,399,421.78	315,647,669.63
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,883,000.00	7,141,000.00
210104	Урамшуулал	61,144,077.20	89,907,581.82
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	99,681,298.63	120,230,797.84

210201	Тэтгэврийн даатгал	68,971,260.71	82,199,799.79
210202	Тэтгэмжийн даатгал	6,786,639.19	9,618,399.51
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,987,199.10	4,809,299.63
210204	Ажилгүйдлийн даатгал	3,987,199.63	4,366,399.48
210205	Эрүүл мэндийн даатгал	15,949,000.00	19,236,899.43
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		
		38,944,309.56	86,448,425.41
210301	Гэрэл, цахилгаан	9,100,309.56	11,590,925.41
210302	Түлш, халаалт	29,844,000.00	74,857,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал		
		49,441,702.84	85,641,996.53
210401	Бичиг хэрэг	4,229,900.00	5,950,500.00
210402	Тээвэр, шатахуун	30,017,100.00	34,473,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,428,899.84	2,401,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,488,500.00	4,507,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,263,303.00	5,598,000.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	2,014,000.00	00.00
210408	Бараа материал акталсны зардал	00.00	32,711,196.53
2105	Нормативт зардал		
		110,443,461.00	108,165,497.19
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	92,573,732.00	73,620,428.19
210502	Хоол, хүнс	16,979,489.00	29,849,069.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	890,240.00	4,696,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		
		19,366,650.00	4,750,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,075,600.00	00.00
210604	Урсгал засвар	16,291,050.00	4,750,200.00
2107	Томилолт, зочны зардал		
		7,604,000.00	5,180,000.00
210702	Дотоод албан томилолт	7,604,000.00	5,180,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		
		2,473,193.00	5,009,807.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	582,000.00	623,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	806,400.00
210803	Даатгалын үйлчилгээ	516,000.00	515,910.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	146,500.00	445,804.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	451,000.00	2,273,000.00
210807	Газрын төлбөр	345,693.00	345,693.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		
		169,006,612.33	176,739,317.73
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,630,000.00	450,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	162,376,612.33	176,289,317.73
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		
		268,690.44	91,374.59
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг		
		00.00	00.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		
		238,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	238,000.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг		
		30,690.44	91,374.59
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	30,690.44	91,374.59
213304	Хөрөнгийн	00.00	00.00

3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	308,753,780.91	-136,091,059.08
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	6,622,222.40	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	6,622,222.40	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-6,622,222.40	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	302,131,558.51	-136,091,059.08

2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,125,316,602.86	1,533,881,748.24
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	11,226,125.00	102,023,346.39
120	Нийтлэг татварын бус орлого	11,226,125.00	102,023,346.39
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	11,226,125.00	102,023,346.39
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	11,226,125.00	102,023,346.39
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,114,090,477.86	1,431,858,401.85
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	11,000,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	73,080,000.00	74,547,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	73,080,000.00	74,547,500.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,041,010,477.86	1,346,310,901.85
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,041,010,477.86	1,346,310,901.85
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,118,517,971.05	1,434,818,529.05
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,118,517,971.05	1,434,818,529.05
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,118,487,280.61	1,434,727,154.46
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	794,255,420.58	958,588,159.58
210101	Үндсэн цалин	468,721,159.02	545,891,908.13
210102	Нэмэгдэл	254,507,185.36	315,647,669.63
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,883,000.00	7,141,000.00
210104	Урамшуулал	61,144,076.20	89,907,581.82
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	99,681,299.63	120,230,797.84
210201	Тэтгэврийн даатгал	67,783,300.00	81,756,899.79
210202	Тэтгэмжийн даатгал	7,974,600.00	9,618,399.51
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,987,200.00	4,809,299.63
210204	Ажилгүйдлийн даатгал	3,987,199.63	4,809,299.48
210205	Эрүүл мэндийн даатгал	15,949,000.00	19,236,899.43

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	63,549,309.56	67,140,925.41
210301	Гэрэл, цахилгаан	9,100,309.56	11,590,925.41
210302	Түлш, халаалт	54,449,000.00	55,550,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	43,564,859.84	52,186,900.00
210401	Бичиг хэрэг	4,704,560.00	5,127,500.00
210402	Тээвэр, шатахуун	29,421,600.00	33,943,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,428,899.84	2,401,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,376,500.00	4,620,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,633,300.00	6,094,400.00
2105	Нормативт зардал	96,299,948.00	211,834,364.63
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	73,920,348.00	175,451,064.63
210502	Хоол, хүнс	20,279,600.00	25,858,300.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,100,000.00	10,525,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,188,650.00	12,751,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,053,000.00	620,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	650,000.00	00.00
210604	Урсгал засвар	6,485,650.00	12,131,200.00
2107	Томилолт, зочны зардал	7,604,000.00	5,180,000.00
210702	Дотоод албан томилолт	7,604,000.00	5,180,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	00.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,498,193.00	5,009,807.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	574,000.00	623,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	806,400.00
210803	Даатгалын үйлчилгээ	516,000.00	515,910.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	146,500.00	445,804.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	451,000.00	2,273,000.00
210807	Газрын төлбөр	345,693.00	345,693.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,845,600.00	1,805,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,845,600.00	1,805,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	30,690.44	91,374.59
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	30,690.44	91,374.59
213304	Төвлөрүүлэх шилжүүлэг	30,690.44	91,374.59
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	6,798,631.81	99,063,219.19
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	6,853,400.00	27,728,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	6,853,400.00	27,728,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	6,853,400.00	27,728,000.00

225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	6,853,400.00	27,728,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-6,853,400.00	-27,728,000.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-54,768.19	71,335,219.19
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	72,356.25	17,588.06
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	17,588.06	71,352,807.25

2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нооц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	499,155,393.85	288,016,931.00	-295,278,831.92	00.00	491,893,492.93
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	499,155,393.85	288,016,931.00	-295,278,831.92	00.00	491,893,492.93
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	10,318,089.14	00.00	10,318,089.14
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	523,795,393.85	302,088,176.16	1,006,202,056.96	00.00	1,832,085,626.97
D01	2025 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	523,795,393.85	302,088,176.16	1,006,202,056.96	00.00	1,832,085,626.97

D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	22,755,109.68	00.00	22,755,109.68
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	523,795,393.85	302,088,176.16	1,028,957,166.64	00.00	1,854,840,736.65
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-22,755,109.68	00.00	00.00	-22,755,109.68
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валогын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-136,091,059.08	00.00	-136,091,059.08
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	523,795,393.85	279,333,066.48	892,866,107.56	00.00	1,695,994,567.89

2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,387,999,029.05	1,387,999,029.05
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,387,999,029.05	1,387,999,029.05
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,387,999,029.05	1,387,999,029.05
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	958,588,159.58	958,588,159.58
210101	Үндсэн цалин	545,891,908.13	545,891,908.13
210102	Нэмэгдэл	315,647,669.63	315,647,669.63
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,141,000.00	7,141,000.00
210104	Урамшуулал	89,907,581.82	89,907,581.82
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	120,230,797.84	120,230,797.84
210201	Тэтгэврийн даатгал	81,756,899.79	81,756,899.79
210202	Тэтгэмжийн даатгал	9,618,399.51	9,618,399.51

210203	ҮОМШӨ-ний даатгал	4,809,299.63	4,809,299.63
210204	Ажилгүйдлийн даатгал	4,809,299.48	4,809,299.48
210205	Эрүүл мэндийн даатгал	19,236,899.43	19,236,899.43
2104	Хангамж, бараа материалын зардал	52,186,900.00	52,186,900.00
210401	Бичиг хэрэг	5,127,500.00	5,127,500.00
210402	Тээвэр, шатахуун	33,943,600.00	33,943,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,401,000.00	2,401,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,620,400.00	4,620,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,094,400.00	6,094,400.00
2105	Нормативт зардал	218,334,364.63	218,334,364.63
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	181,951,064.63	181,951,064.63
210502	Хоол, хүнс	25,858,300.00	25,858,300.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	10,525,000.00	10,525,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	26,664,000.00	26,664,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,848,000.00	10,848,000.00
210602	Тавилга	11,000,000.00	11,000,000.00
210604	Урсгал засвар	4,816,000.00	4,816,000.00
2107	Томилолт, зочны зардал	5,180,000.00	5,180,000.00
210702	Дотоод албан томилолт	5,180,000.00	5,180,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,009,807.00	5,009,807.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	623,000.00	623,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	806,400.00	806,400.00
210803	Даатгалын үйлчилгээ	515,910.00	515,910.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	445,804.00	445,804.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,273,000.00	2,273,000.00
210807	Газрын төлбөр	345,693.00	345,693.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1805000.00	1805000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,805,000.00	1,805,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,386,875,200.00	1,459,334,248.24
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,327,062,500.00	1,346,310,901.85
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,327,062,500.00	1,346,310,901.85
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	59,812,700.00	102,023,346.39
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	59,812,700.00	102,023,346.39
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	17,588.06
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	71,352,807.25
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	40.00	37.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	27.00	26.00

2.6 АУДИТ ХИЙСЭН ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН*/төгрөгөөр/*

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	74,547,500.00	74,456,125.41	91,374.59	99.9%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	74,547,500.00	74,456,125.41	91,374.59	99.9%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	74,547,500.00	74,456,125.41	91,374.59	99.9%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	67,192,500.00	67,140,925.41	51,574.59	99.9%
210301	Гэрэл цахилгаан	11,145,000.00	11,590,925.41	-445,925.41	104.0%
210302	Түлш, халаалт	55,550,000.00	55,550,000.00		100%
210303	Цэвэр, бохир ус	497,500.00		497,500.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,355,000.00	7,315,200.00	39,800.00	99.5%
210604	Урсгал засвар	7,355,000.00	7,315,200.00	39,800.00	99.5%
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	74,547,500.00	74,456,125.41	91,374.59	99.9%
1310	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	74,547,500.00	74,456,125.41	91,374.59	99.9%
132001	Орон нутгийн төсвөөс	74,547,500.00	74,456,125.41	91,374.59	99.9%
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	40.00	37.00	3.00	92.5%
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	0.00	100%
620002	Гүйцэтгэх ажилтан	27.00	26.00	1.00	100%
620003	Үйлчлэх ажилтан	12.00	10.00	2.00	83.3%

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Баруунтуруун сумын Эрүүл мэндийн төвийн дунд хугацааны стратегийг боловсруулах, үйлчлүүлэгчдэд ээлтэй чанартай тасралтгүй, тэгш хүртээмжтэй эрүүл мэндийн шатлалын төрийн үйлчилгээг үзүүлэн хүн амын эрүүл мэндийг сайжруулах өвчлөл эндэгдлийг бууруулахад оршино.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Баруунтуруун сумын Эрүүл мэндийн төвийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Эрүүл мэндийн төвийн тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ хадалдан авах тухай хууль
- Хэмнэлтийн тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Татварын тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль

Тайлант хугацаанд санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ✓ Нийгмийн даатгалын ерөнхий хууль 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөгдсөн
- ✓ Төрийн албаны тухай хуульд -2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр, 05 дугаар сарын 04-ний өдөр, 06 дугаар сарын 16-ны өдөр, 07 дугаар сарын 07-ны өдөр, 11 дүгээр сарын 10-ны өдөр, 12 дугаар сарын 07-ны өдөр ,2025 оны 06 дугаар сарын 05-ны өдөр
- ✓ Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2024 оны 10 дугаар сарын 07-ны 3 дугаар тогтоолоор улсын хэмжээнд мөрдөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн сард 792.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон.
- ✓ Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн А/3 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”
- ✓ Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоолоор
- ✓ Төрийн болон орон нутгийн өмчийн бараа ажил үйлчилгээ худалдаа авах тухай хуульд 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдөр тус тус шинэчлэн тогтоосон байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баруунтуруун сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баруунтуруун сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны 03 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 128,082.7 мянган төгрөгөөр буюу 6.9 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	17,6	71,352.8	71,335.2
Авлага	178,259.0	52,098.3	-126,160.7
Бараа материал	115,468.3	183,738.9	1,721.9
Үндсэн хөрөнгө	1,555,866.7	1,414,338.9	-141,527.8
Нийт хөрөнгө	1,849,611.6	1,721,528.9	-128,082.7
Өр төлбөр	17,526.0	25,534.4	8,008.4
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,832,085.6	1,695,994.5	-136,091.0
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,849,611.6	1,721,528.9	-128,082.7

Төрийн сан дахь харилцах дансны үлдэгдэл нь өмнөх оны үзүүлэлтээс 71,335.2 мянган төгрөгөөр өссөн байна.

Авлага дансны үлдэгдэл 52,098.3 мянган төгрөг болж 126,160.7 мянган төгрөгөөр эрүүл мэндийн даатгалаас авах санхүүжилтийн авлага буурсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 183,738.9 мянган төгрөг болж 1,721.9 мянган төгрөгөөр өссөн нь худалдаж авсан хүнсний материал, аж ахуйн материалаас шалтгаалжээ. Бараа материал дансны үлдэгдэлд худалдаж авсан ашиглалтгүй бараа материал байхгүй болно.

Өр төлбөр дансны үлдэгдэл 25,534.4 мянган төгрөг болж 8,008.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн түлш халаалтын зардлын өр үүссэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,414,338.9 мянган төгрөг болж, 141,527.8 мянган төгрөгөөр буурсан нь элэгдлийн зардал өссөнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,695,994.5 мянган төгрөг болж 136,091.0 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг эрүүл мэндийн даатгалын сангаас 1,368,854.4 мянга, орон нутгийн төсвөөс 74,547.5 мянган төгрөгөөр нийт 1,443,401.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийг 22,543.5 мянган төгрөгөөр бууруулж баталжээ.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,462,455.1 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байгаа нь байр ашиглалтай холбоотой зардал 51.6 мянга, урсгал засварын зардал 39.8 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Туслах үйл ажиллагааны орлого/80102/	59,812.7	71,422.3	-11,609.6	119%
2	Нэг иргэнд нормитивт зардал /80302/	837,127.0	837,126.9	6.6	99.9%
3	Үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээний зардал /81603/	311,676.4	358,594.4	-46,918.0	115.1%
4	Нэмэлт дээд шатны төсвөөс хуваарилсан	182,459.1	181,190.5	1,268.5	99.6%
5	Засгийн газрын болон ЗД-ын нөөц хөрөнгөнөөс хуваарилсан		11,000.0	0.00	100%
6	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал/80111/	74,547.5	74,547.5	0.00	100%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "Нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Баруунтуруун сумын Эрүүл мэндийн төвийн нэмэлт санхүүжилтийн дансаар орлого, зарлага гараагүй байна.

3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Баруунтуруун сумын Эрүүл мэндийн төвийн тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Баруунтуруун сумын Эрүүл мэндийн төв нь 2025 онд 25.856.3 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй хоол хүнсний материалыг шууд худалдан авалтын гэрээ хийж хувь хүнээс мах, сүүн бүтээгдэхүүн, "Номинхөхийн туруун" ХХК-тай боорцог, талх, "Хүчтэн" ХХК-аас хүнсний бүтээгдэхүүнүүдийг тус тус нийлүүлэхээр гэрээ хийж худалдан авалт хийжээ.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баруунтуруун сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баян жанжин хишиг аудит ХХК-ийн аудитор А.Дугармаа гүйцэтгэж, хяналтыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Р.Аюуш, аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Баруунтуруун сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баян жанжин хишиг аудит ХХК-д 2026 оны 01 дүгээр сарын 20-ний өдрийн 01 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,086,038.7 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 10,860.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,550,845.6 мянган төгрөгийн 1 хувиар буюу 15,508.4 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 12,406.7 мянган төгрөгөөр тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Баруунтуруун сумын Эрүүл мэндийн төвийн хувьд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлсэн.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил гараагүй болно. /АБ-4/

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга,

нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 171 мэдээллээс байршуулах хугацаа болоогүй 2, хугацаандаа мэдээлээгүй 16, хугацаа хоцроож 13 мэдээлэл, хугацаандаа мэдээлсэн 153 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалтыг хэрэгжүүлээгүй, "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдэлтэй нийцээгүй гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төрийн аудитын байгууллагаас 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитаар баримтлах ерөнхий чиглэлд тусгагдсан болон бусад хууль тогтоомжтой холбоотой хэрэгжүүлсэн горим сорилын хүрээнд зөрчил илрээгүй болно.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Баруунтуруун сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгдсэн болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөөгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Баруунтуруун сумын Эрүүл мэндийн төвийн хувьд дараагийн аудитаар анхаарах чухал асуудал байхгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 73,250.6 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдааг аудитын явцад залруулж баталгаажуулав.

Залруулсан алдаа:

- Үр дүнгийн тайланд нийт 32,711.2 мянган төгрөгийн бараа материал акталж данс бүртгэлээс хасахдаа бараа материал акталсны зардалд тайлагнаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Аж ахуйн нэгж, байгууллага дараах бүртгэлийн стандартыг дагаж мөрдөнө", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасныг зөрчсөн тул залрууллаа.
- Мөнгөн гүйлгээний тайланд 27,728.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан зардлыг хөрөнгө оруулалтын мөнгөн зардлаар тайлагнаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Аж ахуйн нэгж, байгууллага дараах бүртгэлийн стандартыг дагаж мөрдөнө", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн

байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэж заасныг зөрчсөн тул залрууллаа.

- Үндсэн хөрөнгө тодруулгын тайланд Аймгийн ИТХ-ын тогтоолоор акталсан 12,811,4 мянган төгрөгийн барилгыг үндсэн хөрөнгийн тодруулгын тайланд худалдсанаар тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэж заасныг зөрчсөн тул залрууллаа.

5.1 Зөвлөмж

1. Жолоочийн замын хуудасны тооцоо бодолтой холбоотой асуудал

Илрүүлэлт:

Баруунтуруун сумын Эрүүл мэндийн төв нь 1,563.5 литр буюу 5,745,8 мянган төгрөгийн АИ-92 бензинийг баталгаажаагүй жолоочийн замын хуудсаар тооцоо бодож зарлагын гүйлгээ хийж тайлагнасан.

Өгсөн зөвлөмж:

Зам тээврийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 390 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална”, 13 дугаар зүйлийн 13.5-д “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно” гэж заасныг мөрдлөг болгон ажиллах.

2. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Баруунтуруун сумын Эрүүл мэндийн төвийн цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 271,853.9 мянган төгрөгийн 8 гүйлгээ, орлогын 835,277.3 мянган төгрөгийн 4 гүйлгээ, байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хөтөлбөр зориулалтын 1,171,294.6 мянган төгрөгийн 1 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан.

Мөн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний 1 мэдээлэл, дараа жилийн төсвийн /зорилтот түвшин/ төсөл 1 мэдээлэл, цалингаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 679,295.6 мянган төгрөгийн 8 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө мөнгө зарцуулах 89,651.4 мянган төгрөгийн 6 шийдвэр, бүгд 16 мэдээлэл мэдээлээгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Цаашид Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Загийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийг агуулга, нийтлэг стандартыг тогтоох журмыг хэрэгжүүлэн ажиллах.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн дотор Увс аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Запруулсан		Запруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үр дүнгийн тайланд тайлагнаагүй	1	32,711.2					1	32,711.2				
Мөнгөн гүйлгээний тайланд тайлагнаагүй	1	27,728.0					1	27,728.0				
Үндсэн хөрөнгийн тодуулгын тайланд тайлагнаагүй	1	12,811.4					1	12,811.4				
ДҮН	3						3	73250.6				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Баталгаажаагүй замын хуудсаар АИ 92 бензин зарлагдсан													
Дүн													

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн				
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил												
Шилэн дансны тайланд мэдээллийг хугацаа хоцроож байршуулах, мэдээлээгүй	1	1,196,782.6							1	1,196,782.6		

Дүн	1	1,196,782.6					1	1,196,782.6
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН: БАЯН ЖАНЖИН ХИШИГ АУДИТ
ХХК-ийн ЗАХИРАЛ, АУДИТОР

АУДИТЫН ТАЙЛАНГ



/М.БАТСУУРЫ/

/М.БАТ-АМГАЛАН/

/А.ДУГАРМАА/

2026 оны 02 дугаар сарын 08-ны өдөр